

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД,  
ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны 11 дүгээр  
сарын 17 ны өдөр

Дугаар А/119 / А/137 / А/616

Улаанбаатар хот


Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг  
хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Тагнуулын байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6 дахь заалт, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Үндэсний стратеги батлах тухай” 493 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Б.Батцэцэг), Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газрын дарга (хурандаа Ц.Хүрэлбаатар), Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын цэргийн командлагч (хурандаа Ж.Молорболд) нарт үүрэг болгосугай.

3.Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах, стратегийн зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийн үе шат дуусах бүрд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг Кибер аюулгүй байдлын зөвлөлд танилцуулахыг Кибер аюулгүй байдлын Зөвлөлийн ажлын албаны дарга (Ч.Золбаяр)-д даалгасугай.



Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Тагнуулын ерөнхий газрын дарга,  
Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 1024 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн  
АМНЗ/АМЗ/М дугаар хамтарсан тушаалын хавсралт 616

“КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зорилтот түвшин	Хэрэгжих хугацаа (он)	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт	Санхүүжилтийн эх үүсвэр, Шаардагдах хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Хэрэгжүүлэх байгууллага
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1. Кибер аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалтыг бэхжүүлэх							
1. Кибер аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчны индекс							
1.	Кибер аюулгүй байдлыг хангах хууль эрх зүйн орчинг бэхжүүлэхэд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай хуулийг судалж, тогтооно.	Кибер аюулгүй байдлын Зөвлөл, түүний Ажлын албыг байгуулсан байна. Хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай хууль байгаа эсэхийг судалсан байна. Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийн 5.1-ийн зорилт 1.1-ийн 2025 онд заасан зорилтот түвшинд хүрсэн байна. Судалгаанд үндэслэн нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай хуулийн төслийг боловсруулж батлуулсан байна. Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийн 5.1-ийн зорилт 1.1-ийн 2027 онд заасан	2023  2024-2025  2026-2027	2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Кибер аюулгүй байдлын тухай хууль батлагдсан. 2021 оны байдлаар индексийн үзүүлэлт 9.0 байна.	Кибер аюулгүй байдлын Зөвлөл, түүний Ажлын алба байгуулагдсан эсэх, Кибер аюулгүй байдлыг хангах хууль эрх зүйн орчны индекс		ЦХХХЯ, (ХЗДХЯ, ТЕГ)



1	2	3	4	5	6	7	8
		зорилтот түвшинд хүрсэн байна.					
2. Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр баталсан дүрэм, журмын тоо							
1.	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал, Үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөөг батлуулна.	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал, Үндэсний хэмжээний Кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөө батлагдсан байна.	2023		Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал, Кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Улсын төсөв 100.0	ТЕГ (ЦХХХЯ, ЗХЖШ)
		Үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт 40-оос доошгүй хувьд хүрсэн байна.	2024-2025				
		Үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт 90-ээс доошгүй хувьд хүрсэн байна.	2026-2027				
2.	Кибер аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах нийтлэг журам батлах, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 16.1, 17.1, 19.1-д заасан хуулийн этгээд дээрх журамд нийцүүлэн дотоод журам боловсруулна.	Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам батлагдсан байна.	2023		Батлагдсан журам, кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журамтай байгууллагын хувь		ЦХХХЯ (ТЕГ, ЗХЖШ)
		Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 16.1, 17.1, 19.1-д заасан байгууллагуудын 40-аас доошгүй хувь Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журамтай болсон байна.	2024-2025				
		Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 16.1, 17.1, 19.1-д заасан байгууллагуудын 80-өөс доошгүй хувь Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журамтай болсон байна.	2026-2027				

1	2	3	4	5	6	7	8
3.	Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, аудит хийх журмыг батлуулах, Мэдээллийн аюулгүй байдлын аудитын тогтолцоог бэхжүүлнэ.	Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, аудит хийх журмыг батлуулсан байна.	2023		Батлагдсан журам, Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх байгууллагыг бүртгэсэн тоо, Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэсэн байгууллагын тоо		ЦХХХЯ, ТЕГ (Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх бүртгэлтэй хуулийн этгээд)
		Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэдэг байгууллагын тоог 200-аар нэмэгдүүлсэн байна.	2024-2025				
		Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэдэг байгууллагын тоог 400-аар нэмэгдүүлсэн байна.	2026-2027				
4.	Кибер халдлага зөрчилтэй тэмцэх төвүүдийн үйл ажиллагааны дүрэм, журмыг батлуулна.	Кибер халдлага зөрчилтэй тэмцэх төвүүдийн үйл ажиллагааны дүрэм, журам батлагдсан байна.	2023-2024	Кибер аюулгүй байдлын тухай хууль батлагдсан.	Батлагдсан дүрэм, журмын тоо		ЦХХХЯ, ТЕГ, ЗХЖШ
5.	Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий болон төрийн захиргааны төв байгууллагатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах журам батлуулна.	Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий болон төрийн захиргааны төв байгууллагатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах журам батлагдсан байна.	2024-2025		Батлагдсан дүрэм, журмын тоо		ЦХХХЯ, ТЕГ, ЗХЖШ
Нийт: 100.0							
Зорилт 2. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах							
1. Кибер аюулгүй байдлын эрсдэлд суурилсан мэргэшсэн үйл ажиллагааг нэвтрүүлсэн онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын өсөлтийн хувь							
1.	Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлнэ.	Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын 10-аас доошгүй хувь нь эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан байна.	2023-2024	Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын 2.77 хувь нь эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан.	Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан байгууллагын хувь	Улсын төсөв 150.0	ТЕГ, ЦХХХЯ (Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагууд, Эрсдэлийн үнэлгээ хийх бүртгэлтэй
		Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын 50-аас доошгүй хувь нь	2024-2025				

1	2	3	4	5	6	7	8
		эрсдэлийн үнэлгээнд хамрагдаж, эрх бүхий байгууллагаас хүргүүлсэн зөвлөмж шаардлагыг 43-аас доошгүй хувь хэрэгжүүлсэн байна.					хуулийн этгээдүүд)
		Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын 80-аас доошгүй хувь нь эрсдэлийн үнэлгээнд хамрагдаж, эрх бүхий байгууллагаас хүргүүлсэн зөвлөмж шаардлагыг 82.4-өөс доошгүй хувь хэрэгжүүлсэн байна.	2026-2027				
2.	Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчдийн газруудыг төрийн нууцад хамаарах мэдээ, мэдээлэл солилцох тусгай хэрэглээний сүлжээнд үе шаттайгаар холбоно.	27-аас доошгүй Дипломат төлөөлөгчийн газрыг тусгай хэрэглээний сүлжээнд холбосон байна.	2023	Тусгай хэрэглээний сүлжээг байгуулж, 17 дипломат төлөөлөгчийн газрын тоо холбосон.	Тусгай хэрэглээний сүлжээнд холбосон дипломат төлөөлөгчийн газрын тоо	Улсын төсөв 3,000.0	ТЕГ (ГХЯ, ДТГ-ууд)
		39-өөс доошгүй Дипломат төлөөлөгчийн газрыг тусгай хэрэглээний сүлжээнд холбосон байна.	2024-2025				
		49-өөс доошгүй Дипломат төлөөлөгчийн газрыг тусгай хэрэглээний сүлжээнд холбосон байна.	2026-2027				
3.	Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж буй холбогдох биет болон биет бус эд хөрөнгийг үнэлж, ач холбогдлоор нь эрэмбэлнэ.	Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудын 30-аас доошгүй хувийн эд хөрөнгө, мэдээллийн системийн жагсаалт гарсан байна.	2023-2024		Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудын эд хөрөнгө, мэдээллийн системийн жагсаалтад багтсан хувь	Улсын төсөв 1,000.0	ТЕГ (ЦХХХЯ)
		Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудын 80-аас доошгүй хувийн эд хөрөнгө, мэдээллийн системийн жагсаалт гарсан байна.	2024-2025				



1	2	3	4	5	6	7	8
		Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудын эд хөрөнгө, мэдээллийн системийн жагсаалт 100 хувьд хүрсэн байна.	2026-2027				
4.	Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон болон онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй төрийн өмчит хуулийн этгээдийн ашиглах мэдээллийн систем, сүлжээний тоног төхөөрөмжийг шалган баталгаажуулах лаборатори байгуулна.	Цахим шинжилгээний лабораторийн 3 дугаар үе шатыг хэрэгжүүлж үйл ажиллагааг бэхжүүлнэ.	2023	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссаны дагуу Цахим шинжилгээний лабораторийн 1, 2 дугаар үе шатны худалдан авалт хийгдэнэ.	Байгуулсан лаборатори, цахим шинжилгээ хийхээр батлагдсан мэргэшсэн шинжээчийн тоо, кибер халдлага илрүүлэлтийн хувь	Улсын төсөв 2,200.0	ТЕГ
		Цахим шинжилгээний лабораторийн 4, 5 дугаар үе шатыг хэрэгжүүлж мэдээллийн систем, сүлжээний аюулгүй байдлыг хангах тоног төхөөрөмж, программ хангамжийн шинжилгээ хийнэ.	2024-2025				
2. Нөхөн сэргээх үйл ажиллагаа, тасралтгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байгууллагын өсөлтийн хувь							
1.	Тасралтгүй ажиллагаа, нөхөн сэргээх үеийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, мэдээллийн систем, сан, сүлжээг нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлнэ.	Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын 40 хувь нь тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлдэг болсон байна.	2023	Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын 11.5 хувь нь тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж байна.	Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлсэн онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын хувь		КХЗТТөвүүд (Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагууд)
		Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын 80-аас доошгүй хувь нь тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлдэг болсон байна.	2024-2025				
		Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй бүх байгууллагууд тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлдэг болсон байна.	2026-2027				
3. Тоон шинжилгээний дүгнэлт нотлох баримтын эх сурвалж болох нөхцөлийг бүрдүүлэх							
1.	Кибер халдлага, зөрчилд задлан	Лаборатори ашиглалтад орсон байна	2024-2025	Тоон шинжилгээний лаборатори	Тоон шинжилгээний	Улсын төсөв 1,600.0	ТЕГ, ШШҮХ

1	2	3	4	5	6	7	8
	шинжилгээ хийх тоон шинжилгээний лабораторийг байгуулна.	Хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна.	2026-2027	байгуулах төслийн хэрэгжилт 66% (2021 оны байдлаар)	лабораторийн үйл ажиллагаа жигдэрсэн эсэх		
							Нийт: 7,950.0
Зорилт 3.Хүний нөөцийн чадавхыг сайжруулах, шинээр бэлтгэх, давтан сургах							
1. Иргэдийн тоон бичиг үсгийн чадавх							
1.	Иргэдийн тоон бичиг үсгийн чадавхыг судална.	Иргэдийн тоон бичиг үсгийн чадавхыг 47.9 хувьд хүргэсэн байна. Иргэдийн тоон бичиг үсгийн чадавхыг 50 хувьд хүргэсэн байна.	2023-2025  2026-2027	43.8 (2021 оны байдлаар)	Иргэдийн тоон бичиг үсгийн чадавхын хувь		ҮСХ, Өрхийн судалгаа
2.	Ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын хөтөлбөрт Кибер аюулгүй байдлын талаарх агуулга тусгана.	Ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд мэдээллийн технологийн агуулга түүний дотор Кибер аюулгүй байдлын агуулга тусгасан байна. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт 1-р ангиас мэдээлэл технологийн агуулга, 3-р ангиас мэдээлэл технологийн хичээл ордог болохоор тусгах бөгөөд түүнд Кибер аюулгүй байдлын агуулга тусгасан байна.	2023-2024  2025	Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Зорилт 3.1-т туссан	Батлуулсан сургалтын хөтөлбөрт туссан Кибер аюулгүй байдлын талаарх агуулга		БШУЯ (БЕГ)
3.	Кибер аюулгүй байдлыг хангах мэдлэг ойлголт өгөх үндэсний хэмжээний арга хэмжээг жил бүр зохион байгуулна.	Кибер аюулгүй байдал, Мэдээллийн аюулгүй байдлын талаар 1 арга хэмжээ зохион байгуулагдсан байна. Кибер аюулгүй байдал, Мэдээллийн аюулгүй байдлын талаар 2024-2025	2023  2024-2025	Кибер орчинд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилго бүхий "UnSend", "Миний Минийх"	Зохион байгуулагдсан арга хэмжээний тоо	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж 250.0	ЦХХХЯ (И-Монгол академи УТҮГ)



1	2	3	4	5	6	7	8
		онд тус бүр 1 арга хэмжээ зохион байгуулагдсан байна.		арга хэмжээг 2022 оны 11 дүгээр сард зохион байгуулсан.			
2. Кибер аюулгүй байдлын судалгааны хүний нөөцийн индекс							
1.	Кибер аюулгүй байдлын судалгааны хүний нөөцийн индексийг тогтооход шаардлагатай судалгааг хийнэ.	Кибер аюулгүй байдлын судалгааны хүний нөөцийн индекс үзүүлэлтийг 8.58 болгож нэмэгдүүлнэ. Кибер аюулгүй байдлын судалгааны хүний нөөцийн индекс үзүүлэлтийг 9.76 болгож нэмэгдүүлнэ.	2023-2025  2026-2027	Кибер аюулгүй байдлын судалгааны хүний нөөцийн индекс үзүүлэлт 6.82 байна.	Индексийн үзүүлэлт		ОУЦХБ, Кибер аюулгүй байдлын судалгаа
2.	Кибер аюулгүй байдлыг хангах хүний нөөцийг бэлтгэх урт болон богино, дунд хугацааны сургалтаар албан хаагчдыг чадавхжуулж, мэргэшүүлнэ.	Кибер аюулгүй байдлын чиглэлээр богино хугацааны сургалтыг 2 удаа зохион байгуулж, 250 дээш албан хаагчийг хамрагдуулна. Урт хугацааны сургалтад 10 албан хаагчийг сургасан байна. Жил бүр сургалтад хамрагдах албан хаагчдын тоог нэмэгдүүлж, боловсон хүчнийг чадавхжуулсан байна. Сургалтыг чанаржуулж, олон улсын сертификат бүхий сургалтад төрийн байгууллагын 15 албан хаагчдыг хамруулсан байна.	2023-2024  2025  2026-2027	Төрийн байгууллагын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдэд кибер аюулгүй байдал болон мэдээллийн аюулгүй байдлын талаар 2 удаа сургалт зохион байгуулсан.	Зохион байгуулсан урт болон богино, дунд хугацааны сургалтын тоо, сургалтад хамрагдсан суралцагчдын тоо	Гадаадын зээл, тусламж	БШУЯ (ХНХЯ, Их, дээд сургуулиуд, МСҮТ-үүд)
3.	Кибер гэмт хэрэг, терроризмтой тэмцэх тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага (Цахим хөгжил, харилцаа холбооны	Кибер гэмт хэрэг, терроризмтой тэмцэх тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын 3 албан хаагчийг гадаад болон дотоодод сургасан байна.	2023-2024		Сургуулиар бэлтгэгдсэн хүний нөөцийн тоо	Гадаадын зээл, тусламж 300.0	ЗХЖШ, ЦЕГ (ДХИС)



1	2	3	4	5	6	7	8
	яам, Тагнуулын ерөнхий газар, Зэвсэгт хүчин Жанжин штаб, Цагдаагийн Ерөнхий газар, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Кибер халдлага зөрчилтэй тэмцэх төвүүд)-ын хүний нөөцийг сургаж бэлтгэнэ.	Кибер гэмт хэрэг, терроризмтой тэмцэх тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчдыг жил тус бүрд 3 албан хаагчаар нэмэгдүүлж гадаад болон дотоодод сургасан байна. Мэдээлэл солилцох технологи дээр ажиллах 2-3 хүн сургаж бэлтгэсэн байна.	2025				
		Кибер гэмт хэрэг, терроризмтой тэмцэх тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчдыг жил тус бүрд 3 албан хаагчаар нэмэгдүүлж гадаад болон дотоодод сургасан байна.	2026-2027				
4.	Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төвүүдийн Компьютерын ослын яаралтай тусламжийн багуудын хамтарсан дадлагыг зохион байгуулах, мэргэшүүлэх сургалтын арга хэмжээг явуулна.	Жилдээ 1-2 удаа сургалтын арга хэмжээ зохион байгуулсан байна.	2023-2024		Зохион байгуулсан сургалтын арга хэмжээний тоо	Улсын төсөв, гадаадын зээл тусламж	ЗХЖШ (ЦХХХЯ, ТЕГ ЦЕГ, Кибер халдлага зөрчилтэй тэмцэх төв)
		Жилдээ 1-2 удаа сургалтын арга хэмжээ зохион байгуулсан байна.	2025				
		Жилдээ 1-2 удаа сургалтын арга хэмжээ зохион байгуулсан байна.	2026-2027				
5.	Онцгой нөхцөл байдал үүссэн (дайны) үед улсын хэмжээнд кибер орон зайг хамгаалах чадварыг хөгжүүлнэ.	Онцгой нөхцөл байдал үүссэн (дайны) үед улсын хэмжээнд кибер орон зайг хамгаалах 1-2 дадлага сургуулилт хийсэн байна.	2023-2025		Онцгой нөхцөл байдал үүссэн (дайны) үед улсын хэмжээнд кибер орон зайг хамгаалах талаар хийсэн дадлага сургуулилтын тоо		ЗХЖШ (БХЯ, ТЕГ)
		Онцгой нөхцөл байдал үүссэн (дайны) үед улсын хэмжээнд кибер орон зайг	2026-2027				

1	2	3	4	5	6	7	8
		хамгаалах 1-2 дадлага сургуулилт хийсэн байна.					
							Нийт:550.0
Зорилт 4.Кибер аюулгүй байдлыг хангах хамтын ажиллагааг хөгжүүлэх							
1. Кибер аюулгүй байдлын хамтын ажиллагааны индекс							
1.	Кибер аюулгүй байдлыг хангах хүний нөөцийг чадавхжуулах, судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлэх чиглэлээр дотоод болон гадаадын байгууллагуудтай хамтран ажиллана.	Кибер аюулгүй байдлыг хангах хүний нөөцийг чадавхжуулах, судалгаа шинжилгээний ажлыг гадаадын болон дотоодын аль нэг байгууллагатай хамтран эхлүүлсэн байна.	2023-2024	Хамтын ажиллагааны индекс үзүүлэлт 6.82 байна.	Хийгдсэн судалгаа шинжилгээний үр дүн, Хамтын ажиллагааны индекс үзүүлэлт	Гадаадын зээл, тусламж 50.0	ОУЦХБ, ЦХХХЯ
		Кибер аюулгүй байдлыг хангах хүний нөөцийг чадавхжуулах, судалгаа шинжилгээний ажлын үр дүнг үндэслэн хүний нөөцийг чадавхжуулах ажлыг хийж, Кибер аюулгүй байдлын хамтын ажиллагааны индекс үзүүлэлтийг 8.58 хүргэнэ.	2024-2025				
		Кибер аюулгүй байдлыг хангах хүний нөөцийг чадавхжуулах, судалгаа шинжилгээний ажлын үр дүнг үндэслэн хүний нөөцийг чадавхжуулах ажлыг хийж, Кибер аюулгүй байдлын хамтын ажиллагааны индекс үзүүлэлтийг 9.76 хүргэнэ.	2027				
2.	Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшил, төрийн бус, олон нийтийн байгууллагуудын	Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшил, төрийн бус, олон нийтийн 2 байгууллагатай хамтран ажилласан байна.	2023		Хамтран ажилласан байгууллагын тоо		ЦХХХЯ (Хувийн хэвшлийн байгууллагууд)



1	2	3	4	5	6	7	8
	оролцоог хангах, жижиг, дунд бизнес эрхлэгч, гарааны бизнес эрхлэгч, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын кибер аюулгүй байдлыг хангах ажиллагааг өргөжүүлнэ.	Жижиг, дунд бизнес эрхлэгч, гарааны бизнес эрхлэгч, их сургууль, эрдэм шинжилгээний 2-3 байгууллагатай хамтарч ажилласан байна.  Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшил, төрийн бус, олон нийтийн, жижиг, дунд бизнес эрхлэгч, гарааны бизнес эрхлэгч, их сургууль, эрдэм шинжилгээний 2-3 байгууллагатай хамтарч ажилласан байна.	2024-2025				
3.	Мэдээлэл, харилцаа холбооны техник хэрэгсэл, программ хангамж, электроникийн үндэсний үйлдвэрлэл, инновац, судалгаа шинжилгээ хийж, технологийн хараат бус байдлыг бууруулах төслийг санаачилсан их, дээд сургууль болон бусад байгууллагыг дэмжинэ.	Их, дээд сургууль болон бусад байгууллагуудад хийгдэж буй программ хангамж, электроникийн үндэсний үйлдвэрлэлийн төслүүдээс 2024-2025 онд 1-ийг сонгон шалгаруулж дэмжлэг үзүүлнэ.  Их, дээд сургууль болон бусад байгууллагуудад хийгдэж буй Мэдээллийн технологи, инновац, судалгаа шинжилгээний төслүүдээс 2026-2027 он тус бүр 1-ийг сонгон шалгаруулж дэмжлэг үзүүлнэ.	2025		Дэмжин ажилласан их, дээд сургууль болон бусад байгууллагуудын тоо	Гадаадын зээл, тусламж 300.0	ЦХХХЯ, ТЕГ, ЗХЖШ (Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд)
			2026-2027				

1	2	3	4	5	6	7	8
4.	Онцгой нөхцөл байдал болон гамшгийн үед ашиглах богино долгионы радио холбооны сүлжээг зохион байгуулж, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай харилцан ажиллах.	Онцгой нөхцөл байдал болон гамшгийн үед ашиглах богино долгионы радио холбооны сүлжээг улсын хэмжээнд зохион байгуулж, тусгайлсан чиг үүрэгтэй 9-н байгууллагатай хамтран ажилласан байна.	2024-2025		Нийт худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж буй богино долгионы радио станцын тоо	Улсын төсөв 2,600.0	ТЕГ
		Онцгой нөхцөл байдал болон гамшгийн үед ашиглах богино долгионы радио холбооны сүлжээг улсын хэмжээнд зохион байгуулж, тусгайлсан чиг үүрэгтэй 9-н байгууллагатай хамтран ажилласан байна.	2026-2027				
2. Кибер аюулгүй байдлыг хангах олон улсын байгууллагын гишүүнчлэлийн өсөлт							
1.	Монгол Улсын үндэсний язгуур эрх ашигт харшлахгүй кибер аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын байгууллагад гишүүнээр элсэх, олон улсын болон бүс нутгийн хэмжээний байгууллагуудтай хамтран ажиллана.	Кибер аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын аль нэг байгууллагад гишүүнчлэлээр элсэн орох үйл ажиллагааг эхлүүлсэн байна.	2023	Олон улсын FIRST байгууллагад гишүүнчлэлтэй.	Хамтран ажилласан байгууллагын тоо, гишүүнээр элссэн олон улсын байгууллагын тоо	Улсын төсөв 10.0	ЦХХХЯ, ТЕГ (КХЗТТөвүүд)
		Кибер аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын болон бүс нутгийн хэмжээний 1-2 байгууллагуудтай хамтран ажилласан, 2-оос доошгүй байгууллагад гишүүнээр элсэн орсон байна.	2024-2025				
		Кибер аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын болон бүс нутгийн хэмжээний 4	2026-2027				



1	2	3	4	5	6	7	8
		байгууллагад гишүүнээр элсэн орсон байна.					
							Нийт: 2,960.0
Зорилт 5.Кибер аюулгүй байдлын уян хатан байдал, халдлагад хариу үйлдэл үзүүлэх чадамжийг бүрдүүлэх							
1. Үндэсний тоон гарын үсгийг олон улсад ашиглах нөхцөлийг бүрдүүлэх							
1.	Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчилж, олон улсад итгэмжлэгдсэн байна.	Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн тоног төхөөрөмж бүрэн шинэчлэгдсэн байна.	2024-2025	Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан.	Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн тоног төхөөрөмжийн шинэчлэгдсэн хувь, Олон улсын итгэмжлэл авсан байдал,	Гадаадын зээл, тусламж 5,000.0	ЦХХХЯ (ҮДТ УТҮГ)
		Олон улсад итгэмжлэгдсэн байна.	2026-2027				
2. Олон улсын интернэтийн гарцын өсөлт							
1.	Монголын интернэтийн харилцан холболтын үндсэн сүлжээний өсөн нэмэгдэх хэрэгцээнд тулгуурлан интернэт гарцыг нэмэгдүүлнэ.	Интернэтийн гарцын тоог 3 болгоно.	2024-2025	Олон улсын интернэт гарц 2 байна.	Интернэт гарцыг нэмэгдүүлсэн тоо	Гадаадын зээл, тусламж	ЦХХХЯ (холбогдох бусад байгууллага)
		Интернэтийн гарцын тоо 3-оос доошгүй болсон байна.	2026-2027				
2.	Онцгой нөхцөл байдал болон гамшгийн үед ашиглах тоон технологийн хэт богино долгионы радио холбооны сүлжээг ТЕГ-ын төв болон орон нутгийн салбар, нэгжийн хэмжээнд зохион байгуулна.	Аюулгүй байдлыг хангасан, найдвартай, олон хэрэглээг хангах, үр ашигтай тоон радио холбооны 2-оос доошгүй системийг судалсан байна.	2023		Аюулгүй байдлыг хангасан, найдвартай, үр ашигтай тоон радио холбооны судалсан системийн тоо, бий болсон тоон радио холбооны төвийн тоо, сансрын холбооны хөдөлгөөнт цэгийн тоо, богино долгионы радио холбооны торын тоо, тоон радио холбооны хамрах	Улсын төсөв 19,700.0	ТЕГ
		Тоон радио холбооны төвийг бий болгож, Сансрын холбооны хөдөлгөөнт цэг бий болгосон байна.	2024-2025				
		Хэт богино долгионы радио холбооны тор үүсгэж, Тоон радио холбооны хамрах хүрээг 21 аймагт өргөтгөсөн байна.	2026-2027				

1	2	3	4	5	6	7	8
					хүрээг өргөтгөсөн тоо		
3.Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төв							
1.	Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Үндэсний, Нийтийн болон Зэвсэгт хүчний төвийг байгуулж, кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлнэ.	Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Үндэсний, Нийтийн, Зэвсэгт хүчний төв байгуулагдсан байна.	2023-2025	Кибер аюулгүй байдлын тухай хууль батлагдсан.	Кибер халдлага зөрчилтэй тэмцэх төвийн тоо, кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны тоо	Улсын төсөв 14,000.0 (Үндэсний төв)	ТЕГ, ЦХХХЯ, ЗХЖШ (КХЗТТөвүүд)
		Кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаа хийсэн байна.	2026-2027			16,618.8 (Зэвсэгт хүчний төв-барилга), Гадаадын зээл, тусламж 7,570.0 (Нийтийн төв)	
2.	Кибер гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мэдээлэл солилцох, хамтран ажиллах үйл ажиллагаанд дэвшилтэт, сүүлийн үеийн технологи нэвтрүүлж, ашиглана.	Технологийн шийдлийн судалгааг эхлүүлсэн байна.	2023	Нэвтрүүлсэн технологийн тоо		Гадаадын зээл, тусламж, Улсын төсөв 14,000.0	КХЗТТөвүүд
		Мэдээлэл солилцох 1 технологи нэвтэрсэн байна.	2024-2025				
		Кибер гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэвшилтэт, сүүлийн үеийн 2-3 технологийг нэвтрүүлсэн байна.	2026-2027				
						Нийт: 76,888.8	
						Нийт: 88,448,800,000 төгрөг	

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ, ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР,  
ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ